

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Дугаар...

Улаанбаатар хот

Тэмдэгтийн хураамжийн хэмжээ тогтоох тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.14 дэх заалт, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн нутаг дэвсгэрт хот доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан тогтоолыг холбогдох хуулийн дагуу захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Эрх зүй, хяналт үнэлгээний хэлтэс (А.Анхбаяр)-т даалгасугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, тусгай зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА

А.БАЯР

ХОТ ДОТОРХ БОЛОН ХОТ ОРЧМЫН НИЙТИЙН ЗОРЧИГЧ ТЭЭВЭР, ТАКСИ
ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХОД ХУРААХ ТЭМДЭГТИЙН
ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ

Д/д	Тусгай зөвшөөрлийн төрөл	Тэмдэгтийн хураамжийн хэмжээ /төгрөг/	Тайлбар
1	Хот доторх нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх	10,000,000.0	Эрх бүхий байгууллагаас тогтоосон замнал, тарифын дагуу, их болон дунд багтаамжийн автобусаар нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг үзүүлсний зөрүү санхүүжилтийг төсвөөс олгодог хуулийн этгээдээс хураах /үндсэн чиглэл/
2	Хот орчмын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх	5,000,000.0	Эрх бүхий байгууллагаас тогтоосон замнал, тарифын дагуу нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг үзүүлсний зөрүү санхүүжилтийг төсвөөс олгодог хуулийн этгээдээс хураах
3	Зорчигч тээврийн буухиа үйлчилгээ эрхлэх	5,000,000.0	
4	Хот доторх туслах чиглэлд нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх	5,000,000.0	
5	Хот орчмын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх	3,000,000.0	Эрх бүхий байгууллагаас тогтоосон замнал, тарифын дагуу нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг үзүүлсний зөрүү санхүүжилтийг төсвөөс олгодоггүй, өөрийгөө санхүүжүүлдэг хуулийн этгээдэд
6	Зорчигч тээврийн буухиа үйлчилгээ эрхлэх	3,000,000.0	
7	Хот доторх туслах чиглэлд нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх	3,000,000.0	
8	Такси үйлчилгээ эрхлэх	3,000,000.0	

ТАНИЛЦУУЛГА

2024 оны 11 дүгээр
сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

Тогтоолын төсөл өргөн мэдүүлэх
үндэслэл, шаардлагын талаар

Нэг. Удиртгал

Нийтийн тээврийн парк шинэчлэл, хүртээмж, үйлчилгээ нь хүн амын нийгмийн асуудал, эрх ашиг, сонирхлыг ихээхэн хөнддөг эмзэг асуудал бөгөөд нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагын хувьд нийтийн тээврийн эрэлт хэрэгцээнээс хамаардаг, зах зээлд өрсөлдөх нэг чухал хүчин зүйл болдог.

Нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газар нь нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн тээврийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулан, тээвэрлэлттэй холбоотой зардлыг зохих журмын дагуу тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллагад хуваарилдаг.

Нийслэл хотын нийтийн тээврийн зорчигч тээврийн үйлчилгээнд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн 5 газар, 14 хувийн хэвшлийн нийт 19 хуулийн этгээд 1216 том, дунд оврын автобусаар, 5 хуулийн этгээд 246 тээврийн хэрэгсэлтэйгээр такси үйлчилгээнд ажиллаж байна.

Иймд байгаль орчинд ээлтэй тогтвортой, хүртээмжтэй, үр ашигтай тээврийн системийг бий болгох, иргэдийг автомашины хэрэглээнээс татгалзуулж, нийтийн тээврийн хэрэгслээр зорчих хандлагыг төлөвшүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай болжээ.

Хоёр. Тогтоолын төсөл өргөн мэдүүлэх хэрэгцээ, шаардлага

Иргэний саадгүй зорчих нөхцөлийг нэмэгдүүлэх, нийтийн тээврийн төрөл, хүртээмж, авто зогсоолын ашиглалтыг сайжруулах, хотын төвлөрлийг сааруулж, гэр хорооллыг орон сууцжуулах, түгжрэл, орчны бохирдлоос үүсэх нийгэм, эдийн засгийн нөлөөллийг бууруулах зорилго бүхий Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийг Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 12 дугаар сарын 17-ны өдөр баталсан.

Улмаар Зөвшөөрлийн тухай хуулийн 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр тус хуулийн 8.1 дүгээр зүйлийн 5.12 дахь хэсэгт зааснаар орон нутгийн, хот доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээг хуулийн этгээд тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх эрх зүйн зохицуулалт нь 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс үйлчилсэн.

Зөвшөөрлийн тухай хуульд оруулсан нэмэлтээр Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 5.12 дахь заалтаар орон нутгийн, хот доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээ эрхлэх тусгай аймаг, нийслэлийн Засаг дарга олгоно.

Энэ хуулийн 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Хуульд өөрөөр заагаагүй бол тусгай зөвшөөрлийг таван жилээс доошгүй, энгийн зөвшөөрлийг гурван жилээс доошгүй хугацаагаар олгоно.", энэ зүйлийн 3 дахь хэсэгт "Энэ зүйлийн 2-т зааснаас бусад зөвшөөрлийг хуульд заасан тохиолдолд хугацаагүй олгож болно." гэж тус тус заасан байна.

Улсын тэмдэгтийн тухай хуулийн тухай 29 дүгээр зүйлийн 29.1.14 дэх заалтаар "орон нутгийн, хот доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээ

эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 3000000-10000000 төгрөг" тэмдэгтийн хураамж төлөхөөр хуульчилсан.

Энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт зааснаар нийтийн тээвэр, такси эрхлэх үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах тэмдэгтийн хураамжийн хэмжээг энэ хуульд заасан хязгаарт багтаан аймаг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

Мөн Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн 7 дугаар зүйлд нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг энэ зүйлийн 7.5.4 дэх заалтаар "нийтийн тээврийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл, бүртгэлийн орлого"-оор бүрдүүлэхээр байна.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах хуулийн 7 дугаар зүйлд зааснаар нийслэл хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, нийтийн тээврийн үйлчилгээний төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилго бүхий нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг дараах арга хэмжээнд зарцуулахаар тусгасан байна. Үүнд:

- нийслэлийн нийтийн тээвэрт ашиглах автобусны чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх;

- шинэ төрлийн багтаамж ихтэй нийтийн тээврийн үйлчилгээг нэвтрүүлэх, хөгжүүлэх;

- нийтийн тээврийн хэрэгслийн эгнээ, автобусны буудал, авто зогсоолыг төлөвлөх, байгуулах, хөдөлгөөн зохион байгуулах техник, хэрэгсэл, зураг, дуу-дүрсний бичлэгийн болон хэмжилт-хяналтын төхөөрөмж суурилуулах, тоноглох;

- нийтийн тээврийн хэрэгсэлд зориулсан авто зогсоол /автопарк/ барих;

- нийтийн тээврийн үйлчилгээг хөгжүүлэх, нийслэл хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах чиглэлийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг санхүүжүүлэх;

- нийтийн тээврийн үйлчилгээг төлөвлөх, зохион байгуулах чиглэлээр ажиллах хүний нөөцийг сургаж, дадлагажуулах.

Иймд Улсын тэмдэгтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт зааснаар нийтийн зорчигч тээвэр, такси эрхлэх үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, түүнийг олгох, сунгах тэмдэгтийн хураамжийн хэмжээг хуульд заасан хязгаарт багтаан аймаг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоохоор хуульчилсан тул тогтоолын төсөл, танилцуулга, захиргааны хэм хэмжээний актын нөлөөллийн шинжилгээг судлан боловсруулав.

ХЯНАСАН:

НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН

ДАРГА

Д.ОТГОНЖАРГАЛ

БОЛӨВСРҮҮЛСАН:

САНХҮҮ, АЖ АХУЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ

ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.БАДАМДОРЖ

**НИЙТИЙН ТЭЭВЭР, ТАКСИ ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ,
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, СУНГАХ ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ХУУЛЬД
ЗААСАН ХЯЗГААРТ БАГТААН ТОГТООХ ТУХАЙ ТОГТООЛЫН ТӨСӨЛД ХИЙСЭН
НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ**

Удиртгал

Захиргааны ерөнхий хуулийн 61 дүгээр зүйлийн 61.4 дэх хэсэгт заасныг үндэслэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/147 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Нөлөөллийн шинжилгээ хийх аргачлал"-ын дагуу "Нийтийн тээвэр, такси эрхлэх үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах тэмдэгтийн хураамжийн хэмжээг хуульд заасан хязгаарт багтаан тогтоох тухай" тогтоолын төсөлд нөлөөллийн шинжилгээг хийж гүйцэтгэв.Үүнд:

- 1.Акт гаргах үндэслэл, шаардлага, зорилт;
- 2.Тухайн актын ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ;
- 3.Акт гарсны дараа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь аливаа байдлаар хөндөгдөх бүлгийг тодорхойлох;
- 4.Хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэх;
- 5.Актыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, техник, эдийн засгийн тооцоо.
6. Тухайн асуудлыг зохицуулж байгаа хүчин төгөлдөр хууль, захиргааны хэм хэмжээний акт байгаа эсэх;

Журмын төсөлд нөлөөллийн шинжилгээ хийхдээ тухайн зохицуулалтуудыг хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй субъектүүд нийтээр дагаж мөрдөх боломжтой, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй эсэх, тухайн шийдвэрийг хэрэгжүүлснээр тавьсан зорилгод хүрч чадах эсэх, холбогдох хуулийн агуулга, зорилго хүрээнд нийцэж байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон.

Тогтоолыг төслийг боловсруулахад нийслэл хотын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг эрхлэгч орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн 5 газар, 14 хувийн хэвшлийн хуулийн этгээд болон 5 хуулийн этгээдийн удирдах албан тушаалтнуудад хууль тогтоомжийн шинэчлэлийн талаар мэдээллийг хүргүүлж, тэдгээрийн санал, хүсэлтийг сонсох зорилгоор хэлэлцүүлгийг зохион байгуулсан болно.

Нэг. Акт гаргах үндэслэл, шаардлага, зорилт

Тээврийн хэрэгслийн тоог хязгаарлах, цаашид хэвийн хэмжээнд байлгахын тулд Улаанбаатар хотын тээврийн эрэлтийн менежмент, ялангуяа түгжрэлийн төлбөрийн тогтолцоог бий болгох нь автомашины хэрэглээг бууруулах, нийтийн тээвэр, моторт бус тээврийн хэрэгслийг идэвхжүүлэх, түгжрэлийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэх судалгааны үр дүн гарсан.

Нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээг хуулийн этгээд нь тусгай зөвшөөрлийн үндсэн эрхлэн явуулах, тэдгээрийн тэмдэгтийн хураамжийг "Нийтийн тээврийг хөгжүүлэх сан"-д хуримтлуулж, хотын нийтийн тээврийн төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх олон улсын жишиг туршлагыг нэвтрүүлэх хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлага тавигдсан байна.

Энэ ч утгаар Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 12 дугаар сарын 07-ний өдөр иргэний саадгүй зорчих нөхцөлийг нэмэгдүүлэх, нийтийн тээврийн төрөл, хүртээмж, авто зогсоолын ашиглалтыг сайжруулах, хотын төвлөрлийг сааруулж, гэр хорооллыг орон сууцжуулах, түгжрэл, орчны бохирдлоос үүсэх нийгэм, эдийн засгийн нөлөөллийг

бууруулах зорилго бүхий Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах хууль батлагдан мөрдөгдөж байна.

Дээрх хуультай хамт Зөвшөөрлийн тухай хууль болон Улсын тэмдэгтийн тухай хуульд нийтийн тээврийн болон такси үйлчилгээ эрхлэх нөхцөл, шаардлагыг тодорхой болгож, уг үйлчилгээг тусгай зөвшөөрөлтэй эрхлэх зохицуулалтыг бий болгосон.

Улсын тэмдэгтийн тухай хуулийн тухай 29 дүгээр зүйлийн 29.1.14 дэх заалтаар "орон нутгийн, хот доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 3000000-10000000 төгрөг" тэмдэгтийн хураамж төлөхөөр хуульчилсан.

Энэхүү хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт зааснаар нийтийн тээвэр, такси эрхлэх үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах тэмдэгтийн хураамжийн хэмжээг хуульд заасан хязгаарт багтаан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоохоор болсон нь энэхүү захиргааны хэм хэмжээний актыг тогтоох бодит хэрэгцээ шаардлага юм.

Хоёр. Тухайн актын өрөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ;

Нийслэл Улаанбаатар хот доторх болон хот орчмын тээвэр болон такси үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийн хэмжээг Улсын тэмдэгтийн тухай хуульд заасан хязгаарт багтаан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоох харилцааг зохицуулна.

Түүнчлэн Нийтийн тээврийн бодлогын газраас тогтоосон замнал, тарифын дагуу их болон дунд багтаамжийн автобус, троллейбусаар нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээ үзүүлсний зөрүү санхүүжилтийг төсвөөс олгогддог болон олгогддоггүй хуулийн этгээдийн дараах онцлогоос хамаарч төлөх тэмдэгтийн хураамжийг ялгамжтайгаар тогтоохыг зорьсон байна. Үүнд:

1. Хот доторх болон нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх
2. Хот орчмын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх
3. Зорчигч тээврийн буухиа үйлчилгээ эрхлэх
4. Хот доторх туслах чиглэлд нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх
5. Такси үйлчилгээ эрхлэх

Гурав. Хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл байдал бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэх

2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүчингүй болсон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар 2001-2011 оны 01 дүгээр сар хүртэл хугацаанд нийтийн тээврийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлөөр эрхэлж байсан байна.

Харин 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээг Иргэний хууль, Автотээврийн хуульд нийцүүлэн тээвэрлэлтийн гэрээгээр аж ахуйн нэгж, байгууллагуудаар гүйцэтгүүлж ирсэн байна.

Хуулийн этгээдийн тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоосноор хүний эрх, эрх чөлөө хязгаарлагдахгүй бөгөөд хуулийн этгээдийн санхүүгийн хэвийн үйл ажиллагаанд саад хориг учруулахгүй болно.

Тэмдэгтийн хураамжийг Нийслэлийн Засаг дарга хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгогдосны дараа нийтийн тээврийг хөгжүүлэх санд төвлөрүүлэх тул аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл байдал бүрдэхгүй болно.

Нэгэнт нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг гагцхүү хуулийн этгээдэд олгох учраас иргэнд энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан тэмдэгтийн хураамж иргэнд хамааралгүй байна.

Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын санхүүгийн чадамж, өөрийн болон түрээсийн тээврийн хэрэгслийн тоо, хүний нөөцийн онцлогоос шалтгаалан улсын тэмдэгтийн хураамжийг ялгавартай тогтоох эсэх асуудал хөндөгдөж байсан.

Харин Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх цаашлаад эрх бүхий байгууллагаас тогтоосон замнал, тарифын дагуу их болон дунд багтаамжийн автобус, троллейбусаар нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээ үзүүлсний зөрүү санхүүжилтийг төсвөөс олгогддог аж ахуйн нэгж, байгууллагууд дээрх тогтоолын төслийг дэмжсэн болно.

Иймд Нийтийн тээврийн бодлогын газраас тогтоосон замнал, тарифын дагуу их болон дунд багтаамжийн автобус, троллейбусаар нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээ үзүүлсний зөрүү санхүүжилтийг төсвөөс олгогддог болон олгогддоггүй хуулийн этгээдээс хамаарч төлөх тэмдэгтийн хураамжийг ялгамжтайгаар тогтоогдсон байна.

Дөрөв. Акт гарсны дараа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийг тодорхойлсон байдал

Тогтоолын төсөл нь дараах бүлгийн хууль ёсны ашиг сонирхол, эрх хөндөгдөж болзошгүй гэж үзсэн. Үүнд:

- Нийслэл Улаанбаатар хот доторх, хот орчимд нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагууд
- Нийслэл Улаанбаатар хот доторх, хот орчимд такси үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага

Автотээврийн тухай хуульд зааснаар зорчигч тээвэр, такси үйлчилгээг тээвэрлэлтийн гэрээгээр нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагууд гүйцэтгэж байгаа боловч өнөөдрийг хүртэл Монгол Улсын хууль тогтоомж, стандартыг зөрчин үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд, иргэний үйл ажиллагаа Зөвшөөрлийн тухай хуулиар хязгаарлагдана.

Автотээврийн тухай хуулиар гагцхүү хуулийн этгээдэд нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгогдох бөгөөд энэ тохиолдолд Монгол Улсын хууль, стандартыг хангасан байх шаардлага тавигдана.

Зөвшөөрлийн тухай 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Хуульд өөрөөр заагаагүй бол тусгай зөвшөөрлийг таван жилээс доошгүй, энгийн зөвшөөрлийг гурван жилээс доошгүй хугацаагаар олгоно." гэж тус тус заасан.

Улмаар Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.6 дахь хэсэгт "Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд заасан зөвшөөрөлд хамаарах улсын тэмдэгтийн хураамжийг зөвшөөрөл олгох болон сунгах тухай шийдвэр гарсныг мэдэгдсэнээс хойш ажлын гурван өдөрт багтаан төлнө." гэж заасан байна.

Иймд нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд 5 жилийн хугацаанд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон улсын тэмдэгтийн хураамжийг хуулийн этгээдүүдийн удирдах ажилтнууд хамгийн багаар тогтоолгон төлөх талаар дурдаж байсан.

Гэвч тухайн хуулийн этгээдийн хэвийн үйл ажиллагаанд сөрөг үр дагаврыг бий болгохгүй цаашлаад нийтийн тээврийг хөгжүүлэх санд төвлөрч хуульд заасан

үндэслэлээр зарцуулагдах эрх зүйн зохицуулалтыг сайшаан дэмжиж байсныг тэмдэглэж байна.

Тав. Тухайн асуудлыг зохицуулж байгаа хүчин төгөлдөр хууль, захиргааны хэм хэмжээний акт байгаа эсэх

Улсын тэмдэгтийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.14 дэх заалт "орон нутгийн, хот доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 3 000 000-10 000 000 төгрөг." буюу нийтийн тээвэр, такси эрхлэх үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах тэмдэгтийн хураамжийн хязгаарыг тогтоосон.

Энэхүү хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт зааснаар нийтийн тээвэр, такси эрхлэх үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах тэмдэгтийн хураамжийн хэмжээг хуульд заасан хязгаарт багтаан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоохоор хуульчилсан.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах хуулийн 7 дугаар зүйлд зааснаар нийтийн тээврийг хөгжүүлэх санд энэ зүйлийн 7.5.4-т "нийтийн тээврийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл, бүртгэлийн орлого;"-ыг төвлөрүүлэхээр хуульчилсан байна.

Харин өнөөдрийг хүртэл нийтийн тээвэр, такси эрхлэх үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоосон захиргааны хэм хэмжээний акт батлагдаагүй байна.

Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1381 дүгээр захирамжийн хавсралтаар баталсан Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль болон дагалдан гарсан бусад хуулиудад тусгагдсаны дагуу боловсруулах шаардлагатай баримт бичгийн жагсаалтын дагуу дараах захиргааны хэм хэмжээний актуудын төсөл, танилцуулга, статистик судалгаа, нөлөөллийн шинжилгээг боловсруулж Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн байна.

Тухайлбал, энэхүү жагсаалтын 9 дэх хэсэгт заасан Нийслэлийн нутаг дэвсгэрт хот доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээг батлах тухай Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолын төслийг Газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 01/01/59 дугаартай албан бичгээр Нийслэлийн Татварын газрын даргад санал авахаар хүргүүлж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолын төслийг Газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 01/01/69 дугаартай албан бичгээр хүргүүлсэн байна.

Зургаа. Хүний нөөц, эдийн засгийн тооцоо

Энэхүү тогтоолын хэрэгжилтийг Нийслэлийн Татварын хэлтэс, Нийтийн тээврийн бодлогын газар хамтран хариуцан зохион байгуулах бөгөөд захиргааны хэм хэмжээний акт батлагдсанаар хүний нөөц, эдийн засгийн нэмэлт санхүүжилт шаардлагагүй болно.

Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх найдвартай, байнгын тогтмол эх үүсвэрийг бүрдүүлэх шаардлагын үүднээс "хот доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамж батлах тухай" тогтоолын төсөл батлагдсанаар Нийтийн тээврийн хөгжлийн санд 5 жил тутам 200 гаруй сая төгрөгийн хуримтлал бий болж, нийтийн тээврийн парк шинэчлэлийн санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх боломж олгогдоно.

НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗАР